

Худалдаа ба Хүний хөгжил

*Ч. Насанжаргал, МУИС-ийн ЭЗС-ийн
Олон Улсын Худалдааны*

4-р ангийн оюутан, уралдааны тэргүүн байр

Сайн сайхан амьдал, хөгжил дэвшил, соёл иргэншил, хот сууринг бий болгогч хүн төрөлхтөн та амьтны аймгийн эрхэм дээд төрөл болохоор хүрээлэн байгаа эд юмс бүхэлдээ таны сайн сайхны төлөө тэр аяараа таны өмч гэгдэж та бид түүнийг эрх тэнэг хүүхэд шиг эрээвэр хураавраар бусниулж эдүгээ харин өөрсдийгөө “хүмүүн капитал” хэмээн томъёолчихоод хөгжил дэвшил, соёл иргэншлийн төлөө бие хайргүй зүтгэж, өрөөл бусдаасаа өрсөж, харамлаж өөдтэй яваа эдэлж үлдсэн нэг нь өлсөж яваа нь энэ цагийн төрх бөлгөө. Үнэхээр ч хөгжил гэдэг зүйлийг хүн болгон хүсдэг. Гэвч хөгжил гэдэг энэ зүйл хэний төлөө юм бэ? бид чинь юу ч хийсэн зорилго, зорилт дэвшүүлэн төлөвлөгөө стратеги боловсруулдаг улс. Тэгвэл аливаа хөгжил бол хэзээнээсээ л хүний сайн сайхан амьдралын төлөө бий болдог зүйл. Нэг үгээр хэлбэл, хүн байж байж сая хөгжил дэвшил байна. Өнөөдрийг хүртэл хүн өөрийн нийгэмд асар их хөгжил дэвшлийг байгуулж, өнөөдрийн иргэншсэн дэлхийд хүний хэрэгцээ цом хангагдаж, ёстой л байхгүй юмгүй болжээ гэхэд хилсдэхээргүй бизээ. Техник технологийн асар хурдацтай хөгжил өдөр цагаар хэмжигдэж эдүгээ тогтвортой хөгжлийг илүүд эрхэмлэн нано технологид тэмүүлэх болов. Энэ нь ч техник технологийн асар өндөр дэвшилт ч эцэстээ хүний төлөө үйлчилдэг гэдгийг хүлээн зөвшөөрч буй бас нэгэн ололт юм. Гэвч мэдээж сурсан занг сураар боож болохгүй гэж дэлхий асар өргөн, аливаа иновацийг хүлээж авахдаа хойрго иймээс өнөөгийн дэлхий дээрх төрөл бүрийн өрсөлдөөн, эдийн засгийн өсөлт, эдийн засгийн үзүүлэлтүүдийн шилжилт хөдөлгөөн техник технологийг эзэмших, ашиг орлого олох гэсэн хүсэл тэмүүлэл гэхчлэн юм бүгдийг эдийн засгийн үзүүлэлтээр хэмждэг энэ байдлаас тийм

амархан гарахгүй нь мэдээж. Нөгөөтэйгүүр, манай дэлхийн гадаргуйг агаарын бүрхүүл мэт бүрхэн байгаа улс орнуудын хоорондын харилцаа холбоо, худалдаа наймаа нь хүний хэрэгцээ хөгжил дэвшил хаа байгаа газраас нь импортлох боломжийг олгож байгаа ч энэ нь зөвхөн эдийн засгийн чадавхиар хязгаарлагдаж байна. Энэ бүгдээс үндэслэн нэг талд хүний хөгжил үү, нөгөө талд эдийн засгийн өсөлт үү чухам аль нь зорилго вэ гэдгийг тодорхойлох асуудал юм. 20-р зууны сүүл үе хүртэл дэлхий “эдийн засгийн өсөлтөөс хүний хөгжил” уриан дор эдийн засгийн өсөлтөд анхаарлаа хандуулж байтал дэлхий дээрх 6.2 тэрбум хүний 1.3 тэрбум нь ядууралд автаж, аль ч нийгэмд тэгш бус байдал бий болсон байлаа. Ингээд 21-р зуун бол хүний хөгжлөөс эдийн засгийн өсөлт гэсэн шинэчлэлд нэгдэхийг арга буюу баталж байна. Хүний хөгжлийн үүднээс авч үзвэл, худалдаа бол зорилго биш, харин хөгжлийг түргэтгэх арга хэрэгсэл юм. Худалдаа хүний хөгжилд хувь нэмрээ оруулдаг байхын тулд худалдааны бодлого эдийн засгийн өсөлтийн бодлоготой, өсөлтийн бодлого улс орны хүний хөгжлийг дээшлүүлж байх явдал билээ. Эртнээсээ л хүн хөгжих хэрээр худалдаа хөгжиж иржээ. Энэ нь эхлээд бартерийн худалдаа, үзэсгэлэн худалдаа, биржийн худалдаа, эцэс сүүлд нь электрон худалдаа ноёрхох цаг иржээ. Ийнхүү хүний амьдралд худалдаа маш чухал үүргийг гүйцэтгэсээр бид алхам тутмын үйл ажиллагаагаараа худалдаа наймаанд оролцож байна. Энэхүү хэрэгцээ болон хэрэгцээнээс давсан эрэлтийг хангахын тулд худалдаа эрхлэгчид гэгдэх хүмүүс импортлох экспортлох замаар хаа байгаа газраас нь таны эрэлтэнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг танд хүргэж байна.

Тэд бүр хэрэглэгч биднээс түрүүлж бидний далд эрэлтийг бүтээж байна. Тухайлбал CD-ний хөгжим халаасанд авч явах зориулалтаар гарч байхад бүгд сайшаан хэрэглэж байснаас биш хэн ч MP3, MP4 гараасай гэж бодож байгаагүй билээ. Энэ үйл явцыг тодруулбал, бараа бүтээгдэхүүний дэвшлээр дамжин худалдаа нь хүнд сонголт хийх боломжийг бий болгодог. Нөгөөтэйгүүр, хүний хөгжил бол хүний сонголтыг өргөжүүлж, чадавхийг сайжруулах явдал билээ. Шинжлэх ухаан техник технологи хөгжихийн хэрээр худалдаа нь зөвхөн бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтээс гадна дэвшилтэт технологи, инноваци төрөл бүрийн үйлчилгээ боловсрол эрүүл мэнд зэргийг ч нийлүүлэх болж хүний хөгжилтэй салшгүй уялдаж ихээхэн ач холбогдол өгөх төлөвтэй байна. Худалдаагаар дамжин хүний бүтээмж өсч, чадавхи хийгээд хэрэгцээ хангагдаж байна. Бүр цаашилбал, худалдаа нь олон улсын түвшинд яригдаж улс орны эдийн засгийг хэмжих үзүүлэлт, төсвийн орлогыг бүрдүүлэх эх үүсвэр болж байгаа төдийгүй монголын худалдааны салбарт зах зээлийн харилцаа төлөвшин, хөгжингүй орнуудын нэгэн адил агент, брокер, албан ёсны дистрибьютер, төрөлжсөн бөөний худалдааны төв, төрөлжсөн жижиглэнгийн худалдааны дэлгүүр гэх мэтийн жижиглэн худалдааны цэг салбарууд хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ шаардлагын дагуу төрөлжин хөгжсөөр байна. Тухайлбал Mercedes Benz, BMW, Nissan, Ford, Wrigley's, IBM, Lenovo, Sony, Panasonic, LG, Samsung, Adidas, Nike, Lipton, Dove, Nestle гэх мэт глобал брэнд бүтээгдэхүүний дистрибьютерүүд, Номин, Миний зах, Sity shop зэрэг жижиглэн худалдааны сүлжээ супермаркет, дэлгүүрүүд олон улсын худалдааны стандарт шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлж байна. Түүнчлэн монгол улсад худалдаа бизнесийн цоо шинэ салбар болох кибер орон зайн электрон бөөний (B2B) болон жижиглэнгийн (B2C) худалдаа үүсч хөгжих эхний үе шат амжилттай хэрэгжиж байна.

Ийнхүү монгол улс хүний хэрэгцээг хангах дэлхийн түвшинд хүрсэн худалдааг бий болгожээ. Нөгөөтэйгүүр, хүний хөгжил ба худалдааны уялдааг авч үзэхийн тулд нэг хүнд ноогдох ДНБ, боловсрол, эрүүл мэнд, цаашилбал ядуурал, жендэрийн асуудлуудыг худалдаатай тодруулбал, худалдаанаас олох орлогоос хэрхэн хамаарч байгаад анхаарлаа хандуулъя. Статистикаас харвал 1995-2006 оны байдлаар нэг хүнд ногдох ДНБ-ний бодит хэмжээ бараг 28 хувиар өсч ДНБ-д эзлэх худалдааны салбарын орлого дунджаар 27 хувь, худалдааны салбарын нэмэгдэл өртгийн өсөлт ДНБ-ний өсөлтөөс даруй 2 дахин их байна. Харин нийт ажиллагсдын тоонд худалдааны салбарт ажиллагсад жилээс жилд өсч сүүлийн 13 жилийн турш нийт ажиллагсад 20.1 хувиар өссөн бол худалдааны салбарын ажилчид 161 хувь өссөн байгаа бөгөөд албан бус секторт ажиллагсдын ихэнх нь энэ салбарт амь зууж байна.

Үүнд тулгуурлан худалдаанаас олсон орлого нэмэгдэхийн хэрээр 1 хүнд ногдох ДНБ, Засгийн газраас боловсрол, эрүүл мэндэд зарцуулах төсөв нэмэгдэж байгаагийн дээр худалдаа нь бага өртөгтэй ажлын байрыг нэмэгдүүлж байгаа нь харагдаж байна. Энэ бүгдээс манай улс хөдөлмөр зарцуулалт ихтэй барааны үйлдвэрлэл, экспортыг дэмжих замаар ажлын байрыг бий болгох нь ажилгүйдэл ядуурлыг бууруулж, үндэсний орлогыг нэмэгдүүлэх томоохон боломж юм. Гэвч сүүлийн жилүүдийн практикаас монгол улсын гадаад худалдааны дүр төрхийг сайн ажиглавал ихэнх өргөн хэрэглээний барааг импортолдог, экспортын гол нэрийн бараа нь уул уурхай олборлох аж үйлдвэрийн бүтээгдэхүүн тухайлбал, манай импортын барааны 45.7 хувь, экспортын 27.8 хувийг өмнөд хөрш эзэлж байна. Сонирхолтой нь энэ тоо нь хятадын импортын 0.0007 хувь, экспортын 0.0004 хувийг эзэлж байгаа нь манай орон өргөн хэрэглээний тэр дундаа хүнсний бүтээгдэхүүний хараат байдал

өртөх аюул хаяанд байгааг харуулж байна. Манай улсын төлбөрийн баланс сүүлийн 2 жил ашигтай гарсан нь дэлхийн зах зээлдэх алт, зэсний үнийн өсөлттэй холбоотой гэгдэж, дотоодод инфляци өсч хүн амын үндсэндээ 1/3 нь ядууралд автжээ. Энэ чухам юунаас болов?

Нийгмийн тэгш бус хуваарилалт гэвэл илүү дөхөх болов уу. Арга ч үгүй биз манай үндэсний үйлдвэрлэл муу хөгжсөн, техник технологийн хоцрогдолтой, Засгийн газар нь идэвх муутайн дээр бид хэт бэлэнчлэх сэтгэлээтэй ард түмэн юм.

Эрдэмтэн Ж.Стиглиц “Хөгжил гэдэг хэдэн хүнийг баян болгохыг хэлэхгүй, хөгжил бол нийгэм, эдийн засгийн суурь өөрчлөлт, ядуугийн зовлонгүй, эмнэлэг, сургууль гэх мэт нийгмийн халамж бүхий, хүн бүхэн өөрийн амьдралыг зохион байгуулахад нөхцөл нь бүрдсэн тийм байдлыг хэлнэ. Тиймээс ч хөгжлийг хэдхэн хүн бус хувь заяа нь шийдэгдэж буй бүхий л улс орны ард түмэн, төр засаг, эрдэмтэн, эдийн засагч нарын санал шийдэх учиртай” гэжээ. Энэхүү тэгш бус хуваарилалтыг тэгшитгэж, бүхий л улс орноороо хөгжих нь даяарчлалын эринд 1 хүнээс 1 улс илүү хүчтэйгээр оршин тогтнох нь зайлшгүй юм. Энд улс нийгмийн бодлого чухал ач холбогдлыг үзүүлж байна. Учир нь эдийн засгийн өсөлт, хөгжилт, өөрчлөлт шинэчлэлт гэсээр бүх зүйл зах зээлжиж хүний хөгжлийн гол үзүүлэлтүүд болох эрүүл мэнд, боловсрол зэрэг хүн бүрт хүртэхээ больжээ. Нийгмийн ийм эрс тэс байдал, асар ялгаа бүхий эдийн засгийн чадавхитай ард түмэн зах зээлийн зарчмаар хөгжинө гэдэг худлаа. Уг нь зах зээлийн зарчим бол нэг талд хэрэгцээгээ хангах худалдан авах чадвар бүхий хэрэглэгч, нөгөө талд түүнд хэрэгтэй зүйлийг нийлүүлэх чадвар бүхий нийлүүлэгч хоёрын хоорондын тохиролцоогоор харилцан худалдаа наймааны үйл ажиллагаа явагдсанаар хэрэглэгч бүр нийлүүлэгч (наад зах нь хөдөлмөрийг нийлүүлдэг)

нийлүүлэгч бүр хэрэглэгч гэх замаар нийгэм оршин тогтнох явдал юм. Гэвч манайх бол шилжилтийн эдийн засагтай хөгжиж буй орон, хөгжиж буй эдийн засаг хөгжилтэй зах зээлийн суурь болж чадахгүй. Өөрөөр хэлбэл зах зээлийн биш эдийн засаг хөгжилд саад болж байсан бол одоо хөгжиж буй эдийн засаг зах зээлийн хөгжлийн цар хүрээг тодорхойлох болж шилжилт, хөгжлийн асуудал хамт тавигдаж байна. Ханшны тогтворгүй байдал, хүн амын өдөр тутмын хэрэгцээт бараа үйлчилгээний гачигдал, хэрэглээний хангамжийн доройтол, үнийн өсөлт хөөрөгдөж амьжиргааны түвшин эрс доошилсон, техник технологийн өөрийн гэсэн ололт хомс, гадны патентын эрх мэдэлд автсан шинжлэх ухаан технологийн үндэсний ололт бүтээл дутмаг зэрэг эд болон оюуны баялгаар ядууралд өртсөн шилжилтийн гэгдэх нийгэм, эдийн засгаа яах вэ?

1999 онд Нобелийн шагнал хүртсэн Амартъя Сэн хэмээх эдийн засагч Зүүн Азийн шинээр хөгжиж байгаа орнуудыг судалж үзээд, тэдгээр улсын хөгжлийг түргэтгэсэн хамгийн гол хүчин зүйл бол “Хүний хөгжил” гэж үзсэн байдаг. Хүний хөгжил гэхээр бид 97 хувь бичиг үсэг тайлагдсан орон гэж өөрсдийгөө өндөр боловсролтойгоор санадаг. Хэдийгээр Монгол улсын хувьд хүн амын боловсрол харьцангуй өндөр түвшинд байдаг боловч энэ нь чанарынх гэхээсээ илүү тооных, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ өндөр орлоготой орнуудынхаас 59.5 дахин, дэлхийн дунджаас 11.3 дахин, хөгжиж буй орнуудын дунджаас 2.7 дахин доогуур байна. Эндээс манайд хүний хөгжлийн үзүүлэлтийг сайжруулахын тулд эдийн засгийн өсөлт өөрөөр хэлбэл, нэг хүнд ногдох ДНБ-нийг өсгөх нь чухал байгаа ч энэхүү өсөлт тоон биш чанарын өсөлт байж нийгэм массаараа амьдралын чанар дээшилж баймаар байна. Энд хүнийг чадавхижуулах асуудал мөн чухал байна. Хэсэг тооны баячууд, эрх тушаалтнууд нь нийгмийн бүх баялаг, эрх

мэдлийг атгаж, олонхи болсон ядуу иргэдэд нь ямар ч боломж байдаггүй, хамгийн гол нь тийм байдлаасаа тэмцэж гарах ухамсрын түвшин дорой орон хөгжиж чаддаггүй ажээ.

Ингээд бодоход нийгмийн ухамсрын хувьд ямар механизм Монголд үйлчилж байгаа билээ? Цагдаа дэг журам гэдгээр хэдий хол явах билээ дээ.

Нийгмийн оюун санааны хөгжил гэдэг бэлтгэл хангагдаж байж жинхэнэ утгаараа иргэний нийгэм бүрдэж байж сая зах зээл, ардчиллын механизм эрүүлжиж чадна. Ингэсэн цагт Монголын хөгжилд юу ч саад болохгүй. Хүн ам цөөтэй, цаг уурын тааламжгүй нөхцөлтэй, хоёр их гүрэнд хавчигдсан, дэд бүтэц хөгжөөгүй... эдгээр хүчин зүйлсийн аль нь ч Монголын хөгжлийг зогсоож чадахгүй. Тэртэй тэргүй өнөөдөр дэлхий нийтээр хүн төвтэй хөгжил, хүн төвтэй бизнес, хүн төвтэй Засгийн газар ноёрхох цаг ирнэ манайд ч мөн адил.

Тухайлбал, ядуурлын өвчлөлийн гол шалтгаан болсон бэлэнчлэх сэтгэлгээг устгах, тэдэнд туслах биш тэдэнтэй хамтран ажиллах өөрөөр хэлбэл, тэдэнд чадавхийг бий болгох, улмаар ажлын байрыг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, шинжлэх ухаан техникийн үндэсний ололт амжилтыг өндрөөр үнэлдэг тийм тогтолцоог бий болговол яагаад болохгүй гэж...

Улмаар даяаршлалын шинэ эринд улс орноороо гадаад зах зээл дэх эрэлтийн боломжийг ашиглан өөрийн худалдааны нөхцлөө сайжруулах, худалдаанд илүү үр ашигтай оролцох замаар хүн амынхаа орлогыг нэмэгдүүлж, амьдралын чанарыг сайжруулах замаар хүний хөгжлийг өсгөх боломж нээлттэй байна.